

Батлав: БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын
дарга.....Г.Энхмөнх

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн: “Их говь энерги” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал.....А.Долгөөн

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН МАНДАХ СУМЫН НУТАГ
ДЭВСГЭРТ ОРШИХ “МАНДАХ НУУР” ХАГАС
АНТРАЦИТЫН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ.**

Үндсэн тусгай зөвшөөрлийн дугаар: MV-017196

Нэмэлт тусгай зөвшөөрлийн дугаар: MV-018548, MV-018775, MV-021507

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: № 5522935

Хянасан: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын
хэрэгжилтийн газрын Уул уурхайн нөлөөллийн бодлого, төлөвлөлт хариуцсан
Ахлах шинжээч.....З.Цогтбаяр

Боловсруулсан: “Их говь энерги” ХХК-ийн

Байгаль орчны мэргэжилтэн.....Д.Хуягбаатар

МАНДАХ НУУР 2025 ОН

АГУУЛГА.

1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн нэр.....	3
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага.....	3
1.3. Төслийн байршил.....	3
1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц.....	4
1.5. Уурхайн дэд бүтэц.....	4-7
1.5.1. Уурхайн барилга байгууламж.....	4
1.5.2. Цахилгаан хангамж.....	5
1.5.3. Усан хангамж.....	5-6
1.5.4. Зам харилцаа.....	6
1.6. Уурхайн хүчин чадал болон ажиллах хугацаа.....	6
1.7. Баяжуулах технологи.....	7
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	8-10
2.1. Байгаль орчны төлөв байдлын товч танилцуулга.....	8
2.1.1.Физик газар зүй.....	8
2.1.2. Цаг уур, уур амьсгалын тодорхойлолт.....	8
2.1.3. Гадаргын болон газрын доорх ус.....	8-9
2.1.4. Хөрсөн бүрхэвч.....	9
2.1.5. Ургамлан нөмрөг.....	9
2.1.6. Амьтны аймаг.....	9
2.2. Нийгэм-эдийн засаг.....	9
2.2.1. Дорноговь аймгийн Мандах сум.....	9-10
3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	11
3.1. Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	11
3.2. Газрын гадарга, хэвлий, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	11
3.3. Хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	11
3.4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	11
3.5. Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	11
3.6. Амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөлөл.....	11
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	12
4.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй.....	12

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13-19
1. Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах.....	14
2. Гадаргын болон газрын доорх ус, түүнд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах.....	15-16
3. Хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах.....	17-18
4. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах.....	18
5. Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах.....	18
6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.....	19
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
6.1. Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	21
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22-23
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23-26
11. ХОГ ХАЯГДЛЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27-29
12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	30-31
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	32-33
14. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ.....	34-35
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ.....	36

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

“Мандах нуур” хагас антрацитын ордыг ил аргаар ашиглах төсөл

1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:

“Их говь энерги” ХХК
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **9019064148**
Регистрийн дугаар: **5522935**
Бүртгүүлсэн огноо: **2013.06.19**
Хаяг: УБ хот, СБДүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-5, ИТС центр, 9 дүгээр давхар.
Утас: **77222282, 88623493**

1.3 Төслийн байршил



Дорноговь аймгийн Мандах сумын нутагт байрлах Мандах нуурын хагас антрацитын нүүрсний уурхай нь тус сумаас 117 км, Улаанбаатар хотоос зүүн урагшаа 680 км тус аймгийн Сайншанд хотоос баруун урагш 210 км, Ханги-Мандал боомтоос 165 км зайд оршино

Талбайн хэмжээ: 502.26 га

Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: К-49-14

Хүснэгт 1. MV-017196 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн булангийн цэгүүдийн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1	108°38'44.37"E	43°35'23.70"N
2	108°36'52.39"E	43°35'26.70"N
3	108°36'52.39"E	43°36'31.49"N
4	108°38'44.37"E	43°36'31.49"N



Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг

1.4 Ордын үйлдвэрлэлийн нөөц

“Их говь энерги” ХХК нь Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Төхөм-3 нэртэй MV-017196 тусгай зөвшөөрөл бүхий хагас антрацитын орд ашиглах тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна.

Техник Эдийн Засгийн Үндэслэл –ийн тодотголыг “Роял рэнж” ХХК боловсруулсан ба 2023 оны 12 дугаар сарын 20 -ний өдөр “Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар” хэлэлцэж, АМГТГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн т/20 тушаалаар баталсан.

Үйлдвэрлэлийн нийт ашиглалтын нөөц 37.2 сая.тн, хуулах хөрсний хэмжээ 543.0 сая.м³, хөрс хуулалтын коэффициент 14.2 м³/тн тооцсон байна.

1.5. Уурхайн дэд бүтэц

Мандах нуурын ордод олборлолтын үйл ажиллагаа явуулахад дэд бүтэц талаасаа уурхайн ажилчдын байр, оффис, ШТС, агуулах, засварын хэсэг, ТМА зэрэг барилга, байгууламжийн асуудлууд бүрэн шийдэгдсэн болно.

1.5.1. Уурхайн барилга байгууламж

Уурхайн хотхон ордын баруун хойт хэсэгт байрлана. Хотхон нь ажилчдын амьдрах байр болох зөөврийн сууц, гэр, уурхайн захиргааны байр, гал тогоо, хоолны заал, сургалтын байр, угаалгын газар, засварын газар бараа материалын агуулах, спорт тоглоомын талбай, авто зогсоол зэргээс бүрдэнэ.

Шинээр баригдаж буй ажилчдын амьдрах орон сууц, оффисын цогцолборын барилгын ажил үргэлжлэн явагдаж 2025 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй байна.



Зураг 2. Шинээр баригдаж буй ажилчдын сууц, оффисын барилгын төслийн зураг



Зураг 3. Уурхайн техникийн засварын газар, агуулах.

1.5.2. Цахилгаан хангамж

Цахилгаан хангамжийг 2017 онд Эрчим хүчний яамаар техникийн нөхцөл гаргуулж “Цагаансуварга-Хатанбулаг” чиглэлийн 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамнаас салбарлуулан 35/10кВ-ын дэд станц байгуулж, тус станцаас 10/0.4 кВ-ын дэд станцууд барьж уурхай төвийн ЭХС-д холбогдсон.

1.5.3. Усан хангамж

Унд, ахуйн усны хэрэгцээ:

2011-2012 онуудад Дорноговь аймгийн Мандах сумын нутагт хамаарах уурхайн хотхоны хэрэгцээнд зориулан гаргасан Элгэн-1, УГЦ-1, Кемп-2 худгуудаас унд ахуйн хэрэгцээнд ашиглаж байна. Цооног өрөмдөх зөвшөөрлийг Дорноговь аймгийн БОГазраас авч, худгийг усны улсын бүртгэлд хамруулан паспорт авсан.

Технологийн усны хэрэгцээ:

Уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолт, хуурай аргаар шигшин ялгах зэрэг үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаанд ус ашиглагддаггүй.


Уурхайн карьерт маш бага хэмжээтэй ус шүүрдэг нь уулын ажилд нөлөөлдөггүй учраас гадагш орчин буюу байгальд шавхан зайлуулах шаардлагагүй

байдаг. Харин 2024 оны зун бороо их орж, үерийн ус карьерт орж ирсэн тул 11 сарын эхээс шавхалт хийж эхлэсэн. Энэхүү уснаас зам талбайн усалгаанд ашиглаж байна.

1.5.4. Зам харилцаа

Мандах нуурын уурхай нь Улаанбаатар хотоос 680км, Мандах сумын төвөөс 117 км, Сайншанд өртөөнөөс 210км, Ханги-Мандал хилийн боомтоос 165 км зайтай байрладаг. Нүүрсийг Мандах нуурын уурхайгаас Ханги Мандал боомт хүртэл 171.6 км авто тээврээр тээвэрлэнэ. Гадаад тээврийн автозамын хувьд Мандах нуурын уурхайн талаас Тавантолгой-Ханги боомт чиглэлийн концессын зам хүртэл 64 км газарт далан болон ухмалын ажлын бүрэн хийж дуусгаад байна. Тус уулзвараас боомт хүртэл 107.6 км зайтай. Гадаад тээврийг 70 тн даацтай шланзаар гүйцэтгэхээр тооцлоо.

Ил уурхайн технологийн болон дотоод замын шимт хөрсийг тусад нь авч далан байгуулан, хайрган материалаар хучиж, сайжруулалт, арчилгааг тогтмол хийж байна.



Зураг 4. Замын маршрут


1.6. Уурхайн хүчин чадал болон ажиллах хугацаа

"Мандах нуур" хагас антрацитын ордод 2023 оноос ашиглалтын үйл ажиллагааг сэргээн явуулж эхлээд байна. Ажиллах хугацаандаа ТЭЗҮ, БОННУ зэрэг үндсэн баримт бичгүүдэд үндэслэсэн төлөвлөгөө, газар усны гэрээ зэрэг бичиг баримтыг бүрдүүлэхийг зорин ажиллаж байна.

2025 онд төслийн хэмжээнд нийтдээ 41,442.76 мян.м3 хөрс хуулж, 3932.4 мян.тн нүүрс олборлоно, 44,173.63 мян.м3 уулын цул хөдлөхөөр тооцов. Хөрс хуулалтын дундаж коэффициент нь 10.5 байхаар төлөвлөв.

1.7. Баяжуулах технологи

"Мандах нуур"-ын хагас антрацитын ордын дээжийг Аллайр хуурай аргаар баяжуулах төхөөрөмж дээрх үйлдвэрийн туршилтыг ХБНГерман улсын Хазмер техникийн төвд хийж гүйцэтгэсэн. Туршилтын үр дүн, санал зөвлөмж, техникийн даалгавар, хуурай аргаар баяжуулах арга нь ус ашиглахгүй зэрэг давуу талыг үндэслэн Мандах нуурын антрацитыг гравитацийн буюу хуурай аргаар баяжуулах технологийг сонгон авсан болно.



Зураг 5. Хагас антрацитыг ялгах, баяжуулах үйлдвэрлэлийн бүдүүвч зураг.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.

2.1. Байгаль орчны төлөв байдлын товч танилцуулга.

2.1.1. Физик газар зүй.

Далайн түвшнээс дээш 1307 м өндөр Төхөм хэмээх газар байршсан, Тус сум нь олонд зартай Ашиг хоргын чулуу, Арван наймын богд, Будрын чулуу, Аргалант, Нармандах, Буянт, Ноён, Хоньч, Хорго, Баян-Өлгий, Сүйхэнт зэрэг өвөрмөц үзэсгэлэнт уул хад нүд алдам цэлийсэн уудам тэнэгэр говь хөндий хослон байдаг. Газрын гадаргуугийн 60 орчим хувь нь баруун урдаас зүүн хойш бараг өргөргийн дагуу чиглэсэн бага зэрэг хэрчигдсэн цав гүвээ, жижиг толгод бүхий тэгшивтэр тал зонхилох ба далайн түвшнээс дээш дунджаар 730-940 м өргөгдсөн байдаг. Газрын хөрсний төлөв байдал нь тааламжтай ба ихэвчлэн хайрга, элсэрхэг хайргаар бүрхэгдсэн байна

2.1.2. Цаг уур, уур амьсгалын тодорхойлолт.

Уур амьсгалын хувьд манай орны бүх нутгийн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд хамаарагдах бөгөөд хавар, намар нь богинохон, өвөл, зуны улирал нь урт үргэлжилдэг, халуун, хүйтний хэлбэлзэл ихтэй байдаг. Жилийн аль ч улиралд баруун, баруун хойт зүгийн салхи зонхилж дунджаар 5- 12 м/с-ийн хурдтайгаар салхилдаг. Салхины сарын хэлбэлзэл нь 4, 5, 6-р сарын эхэнд салхилалт хамгийн их, зарим үед шороон шуурга болж салхины хүч 35 м/с хүрч хүн, малын амьдралд хүндрэл учруулдаг. Харин 6-р сарын сүүлээс 9-р сар хүртэл харьцангуй тогтуун 4-9 м/с хурдтай болдог.

Жилд дунджаар 60-120 мм хур тунадас унах ба хамгийн их хүйтэн нь 1-р сард - 24°-35°С, хамгийн дулаан нь 7, 8-р сард дунджаар +30°+42°С дулаан болдог бөгөөд 2002 оны 7-р сард Монгол улсын хэмжээнд Дорноговь аймгийн Мандах сумын нутагт хамгийн их халуун буюу +42°С хүрч байсан. Өвлийн цагт цас бага ордог учир уулын ар өвөр, ар бэл, ам хөндий сайр талаар цасан бүрхүүл бага тогтоно. Энэ бүс нутагт геологийн хээрийн үйлдвэрлэлийн ажил явуулахад 6-10-р сар хүртэлх хугацаанд цаг агаарын хувьд тохиромжтой байдаг

2.1.3. Ус зүйн сүлжээ.

Ус зүйн хувьд талбай нь Говийн их мужид хамаарагддаг тул задгай гол, горхи байхгүй бөгөөд оршин суугчид нь хүнсний болоод ахуйн хэрэгцээндээ дунджаар 2-8 м гүнтэй худгийн усыг хэрэглэдэг. Малчид нь малаа тухайн жилийн хур тунадаснаас шалтгаалан тэжээгддэг ширгэдэг нуураас услах бөгөөд энэхүү нуур нь хур бороогүй гантай жилдээ хуурай нуурын шалыг үүсгэдэг юм. Мандах сумын нутагт Цагаан цавын гүний усны нөөцтэйгөөс гадна зүүн, баруун сухай, Наран, Толь, Гэрчулуу, Гишүүнтэй зэрэг томоохон булаг, ус элбэгтэй бүрд, тойром олонтой юм. Тус сум нь аймагтаа гүний болон гадаргын усны нөөц ихтэй газарт тооцогддог Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн 1 гүний худаг, 45 м3/хоног хүчин чадалтай 1 насос станц, 50 м3/хоног хүчин чадалтай 1 ус зөөлрүүлэх тоног төхөөрөмжтэй сумын

төвийн ус зөөврийн машинаар айл өрх болон албан газрын усыг зөөж түгээдэг байна.

2.1.4. Хөрс, ургамалан бүрхэвч.

Ботаник-газарзүйн мужлалаар говийн цөлөрхөг мужид багтана. Энд говийн хайргархаг элс, дайргархаг-элсэрхэг хөрс тархсан байх бөгөөд энэхүү хөрс нь ялзмаг багатай чийг хадгалалт муутай байдаг. Ус чийг багатай хуурай салхи ихтэй байдаг учир ургамлын бүрхэвч тачир сийрэг байдаг. Хайгуулын талбайд дээрх хөрс, нөхцөлд зохицсон ус чийг бага шаарддаг халуунд тэсвэртэй бутлаг, дэрслэг ургамал ургана.

Энэ районд хазаар өвс, чихэр өвс, цулхир, гоёо, таана, хөмүүл, хулангийн ундаа, харгана, бударгана, шаваг, загсгал, тоорой, заг, хайлаас, сухай зэрэг ургамлууд ургана. Хөмүүл, таана зэрэг сонгинолог ургамлыг хүмүүс хүнсэндээ хэрэглэнэ. Мөн загсгал, чихэр өвс, цульхир зэрэг эмийн ургамлыг эмчилгээнд ашигладаг. Элсэн манхануудад хар суль, цульхир ихээр ургадаг бөгөөд хүмүүс түүж авч хүнсэндээ ашигладаг.

2.1.5. Амьтны аймаг.

Ан амьтны аймгийн хувьд судалгааны талбайн урд, зүүн хөндийгөөр хулан, хар сүүлт талбайн хойт хэсэг цагаан суваргын уулс, толгод тарамцгаар аргаль, хулан, цагаан зээр, хар сүүлт ховроор янгир, махчин амьтдаас чоно, шилүүс, үнэг, хярс, мануул, өмхий хүрэн, дорго, жигүүртнээс тас, бүргэд, сар, тоодог, тогоруу, харцага, болжмор, ногтруу, хулан жороо, хэвлээр явагчдаас могой, гүрвэл, мэрэгчдээс бозлог, алаг даага, оготно зэрэг амьтад алаг цоог байрлалтай оршино.

2.2. Нийгэм-Эдийн засаг.

2.2.1. Дорноговь аймгийн Мандах сум.

Мандах сум нь 1924 оны 08 дугаар сарын 01-ний өдөр үүсгэн байгуулагдсан. Засаг захиргааны 5 багтай. Дорноговь аймгийн баруун хэсэгт байрлан, Зүүн талаараа Сайхандулаан, урд талаараа Хөвсгөл, Хатанбулаг, Улаанбадрах, баруун талаар Өмнөговь аймгийн Манлай, Хойд талаараа Өндөршил, Баруун хойд талаараа Дундговь аймгийн Өлзийт сумтай хиллэдэг ба Улаанбаатраас 454 км, Дорноговь аймгийн төв Сайншандаас 170 км зайтай.

Сумын газар нутгийн нийт хэмжээ 1,266,061.00 га.

Байгалийн нөөц. Сумын нутаг Цагаан суварга, Хөнгөөтийн зэсийн нөөц орд, хоньчийн нүүрсний орд, алт, усан утаат болор, жонш, өнгөт боржин, занар, гипс, шохой, нүүрс, шороон будгийн арвин нөөцтэй. Тус сумын нутагт Цагаан цавын гүний усны нөөцтэйгээс гадна зүүн, баруун сухай, Наран, Толь, Гэр чулуу, Гишүүнтэй зэрэг томоохон булаг ус элбэгтэй бүрд тойром олонтой.

2024 оны байдлаар зуун ерин нэгэн мянга арван найман толгой малтай. Мандах сум 500 өрх, 1585 суурин хүн амтай.

Тус суманд “Монголын алт” ХХК, “Их говь энерги” ХХК, “ЭЙ ВЭЙ ЭКС” ХХК, “Голдон гровуз” ХХК, “KINCORA COPPER” ХХК зэрэг байгууллага уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаагаас гадна өөрийн сумын “Богд мандах” хоршоо, “Говь трайн” ХХК, “Мандах өлзийт” ХХК, “Монгол тарвас” ХХК, “Шувуун хад” ХХК, “Богд хайрхан трейд” ХХК зэрэг аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024 онд “Мандах нуур” хагас антрацитын ордыг ашиглах ТЭЗҮ-д нэмэлт тодотгол хийж батлуулсан тул БОННҮнэлгээний нэмэлт тодотголыг “Говь-Эко” ХХК-аар хийлгэж БОАЖЯамаар хянуулж батлуулсан болно. Энэхүү БОННҮ-ний тодотголд тус төслийг хэрэгжүүлэх явцад дараах сөрөг нөлөөлөл үүснэ гэж тодорхойлсон.

3.1. Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төслийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээнд явах машинууд олон салаа зам гаргаж газрын гадарга талхлах, тэдгээрийн хөдөлгөөнөөс агаарт тоос дэгдэх
- Төслийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс дуу шуугиан үүсэж, орчинд тархах

3.2. Газрын гадарга, хэвлий, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Хөрс хуулалтаас газрын гадаргын унаган төрх өөрчлөгдөх.
- Барилга угсралтын үйл ажиллагаа, машин техникийн хөдөлгөөнөөр газрын гадаргад нөлөө үзүүлнэ.
- Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадарга элэгдэлд орох, хэв шинж өөрчлөгдөх.

3.3. Хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Машин техникийн хөдөлгөөнөөр олон салаа зам үүсэх, газрын гадарга, хөрсөн бүрхэвчид элэгдэл, эвдрэл үүсэх.
- Түүхий эдийн тээвэрлэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэлд өртөх, физик шинж чанар өөрчлөгдөх

3.4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Авто засварын газар болон авто машинаас шатахуун болон шатах тослох материал асгаран хөрсөн бүрхэвчээр дамжин гадаргын болон газрын доорх усанд нэвчих бохирдол үүсэх
- Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хатуу хог хаягдал зэргийн үлдэгдэл угаагдан хөрс, газрын хэвлийг бохирдуулах улмаар гүний усыг бохирдуулах

3.5. Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төслийн барилга байгууламж, тулгуур шон угсрах, шинэчлэх үйл ажиллагаанд ойр ормын ургамлан нөмрөг талхлагдах, устаж үгүй болох
- Төслийн бүхий л үйл явц, түүний хог хаягдал, зам зэрэг үйл ажиллагаанаас буй болох тоосжилт нь ургамал нөмрөг дээр бууж хуримтлагдах

3.6. Амьтны аймаг түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Засвар үйлчилгээ, барилга угсралтын үед ажиллах тээврийн хэрэгсэл, техникүүдийн дуу чимээнээс амьтад үргэн дайжих
- Зэрлэг амьтдын амьдрах таатай орчинд сөргөөр нөлөөлөх, нүүдлийн замд саад хийх

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.

“Их говь энерги” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаварыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах зорилт тавин ажиллаж байна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэх нь БОМТ-ний гол зорилт юм.

“Мандах нуур” уурхайн ашигт малтмал олборлох үеийн бүхий л үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн талбай болон нөлөөллийн бүс нь энэхүү төлөвлөгөөнд хамаарна.

4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

Энэхүү Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд БОННҮнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан олборлолтын үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, хог хаягдлын менежмент, удирдлага зохион байгуулалтын зардал, орчны хяналт шинжилгээ хийхэд шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тооцсон болно. Мөн байгаль хамгаалах зарим нэг урьдчилан тооцоолох боломжгүй зардлыг үйл ажиллагааны болон үйлдвэрлэлийн зардалд тухай бүр нь тусгаж ажиллана.

Хүснэгт 3. БОМТ, ОХШХ-ийн зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		Нийт зардал (төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	6,500,000
2		Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	9,000,000
		Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	2,500,000
3			
4		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4,000,000
5		Осол эрсдлийн менежмент	1,400,000
6		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	2,800,000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	11,400,000
Нийт зардал			37,600,000

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Агаарын чанар, газрын гадарга болон хэвлий, усан орчин, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт учрах аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, өмнөх жилүүдэд үзүүлсэн сөрөг нөлөөллийг арилгах зэрэг ажлуудыг тусган хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд 6.5 сая төгрөг зарцуулах тооцоолол гарсан ба томоохон ажлуудыг үйл ажиллагааны зардалд багтаан шийдвэрлэдэг болно. Сөрөг нөлөөллийг бууруулах талаар зохион байгуулалтын, зардал шаардахгүй ажил нилээд байна.

Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (2025 он)

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1. Агаарын чанар									
1.	-Төслийн үйл ажиллагаа болон задгай талбай, машин техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэж агаарын орчныг бохирдуулах	1.1. Уурхайн карьер, овоолго, зам талбайн усалгаа, нормыг сар улирлаар оновчтой тогтоож, байнга усалгаа чийгшүүлэлт хийж байх	-Технологи, тээвэрлэлтийн зам талбай	м³	Ус ашиглас-ны төлбөр	Ус ашиг-луулах дүгнэлт ээр	-	Бороо-гүй үед өдөр бүр.	-Агаарын тухай -Байгаль орчныг хамгаалах тухай -Ашигт малтмалын тухай хуулиуд -Агаарын чанарын MNS 4585:2016 стандарт
		1.2. Уурхайн ашиглалтын замаас гадна олон салаа зам гаргахгүй байх, дотоод замуудад тэмдэг тэмдэглэгээ байршуулах	-Уурхайн технологийн зам	ширхэг	ХАБ-ын зардалд тусгаг-дана.	50	-	Зам талбай өөрчлөг-дөх	
		1.3. Ил уурхайд ажиллах ажилчдыг тоосны нөлөөллөөс хамгаалах, машин техникийн дотоод орчны битүүмжлэлийг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлаар хангах	-Төслийн талбайд	ширхэг	Засварын зардалд тусгагд-сан	150	-	Тухай бүр	
		1.4. Авто машины дуут дохиог гэнэтийн ослоос сэргийлэхээс бусад үед өгөхгүй байх, оройны 10 цагаас хойш ямар нэгэн олныг хамарсан дуу чимээ гаргуулахгүй байх	-Төслийн талбайд	-	Зардал шаардах-гүй	-	-	Байнга	
		1.5. Ажлын бус цагаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг багасгах	-Төслийн талбайд	-	Зардал шаардах-гүй	-	-	Байнга	

2. Гадаргын ба газрын доорхи усны нөөц									
2.	-Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	2.1. Унд ахуйн усыг хангаж буй гүний худагт эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөж, хог хаягдлаар бохирдохоос урьдчилан сэргийлж ажиллах.	-Кемпийн унд ахуйн худаг	байнга	шаардахгүй	байнга	шаардахгүй	байнга	-Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий гзар хаамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлохыг хориглох тухай -Усны тухай -Хог хаягдлын тухай
	-Шатах, тослох материал хөрсөнд алдагдаж хур тунадас, үерийн усаар угаагдан усан орчинг бохирдуулж болзошгүй	2.2. ШТМ-ын хадгалалт, түгээлтийн технологийн горимыг чанд даган мөрдөнө.	-Маргад Петролиум ХХК-ний ШТС, зөөврийн ШТС, түлш тээвэрлэгч машинууд	байнга	шаардахгүй	байнга	шаардахгүй	байнга	Хөрсний чанрын стандарт MNS 5850:2008

	-Ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг зүй зохистой зайлуулаагүйн улмаас усан орчинг бохирдуулж болзошгүй	2.3. Хог хаягдлын түр цэгийг гадаргын уснаас хол зайд байгуулах, хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулах, хогийн цэгийг халдваргүйжүүлэх	-Хог хаягдал түр хадгалах, булшлах цэгүүд	ширхэг	75,000	12	900.0	14 хоног тутам	-Хог хаягдлын тухай хууль -БОАЖ-ын Сайдын 2018 оны А/445 тушаал
		2.4. Ахуйн бохир усыг цэвэршүүлэх байгууламжтай болно.	-Ахуйн шингэн бохир ус цэвэршүүлэх байгууламж	Байгууламж	Барилгын ажлын зардал	1	-	6-р сард	-Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир усны стандарт MNS 4943:2011
		2.5. Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу тодорхой цэгүүдээс усны дээж авч шинжилгээ хийлгэнэ.	-ОХШХ-т тусгасан цэгүүд	ширхэг	62,500	4	250.0	6, 9 дүгээр сард	
	-Усны хэрэглээг хянах	2.6. Уурхайн ашиглалтын худгуудын тоолуурыг тогтмол хэвийн байлгаж, сум орон нутагт сар бүр хянуулж баталгаажуулах .	-Унд ахуйн худгууд	Удаа	75,000	12	900.0	1-12 сард	-Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль -Ус ашиглах гэрээ, дүгнэлт
3. Хөрс, газрын гадарга									
3.	- Уурхайн дотоод болон гадаад тээвэрлэлт, автомашины хөдөлгөөнөөс хөрс эвдрэлд өртөх, бохирдох	3.1. Тээврийн хэрэгслээс шатах, тослох материал асгарахаас сэргийлэх. Асгарсан тохиолдолд түргэн шуурхай сэргийлэх арга хэмжээ авах.	-Зам талбай	ширхэг	20,000	20	400.0	2 дугаар улиралд багтаан	-Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай, - Байгаль орчныг

	-Хүн, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, хөрсний шороо суларч, элэгдэл эвдрэлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй.	3.2. Шаардлагагүй зам, талбайг үүсгэхгүй байх, маршрутыг оновчтой төлөвлөж, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах.	-Тусгай зөвшөөрлийн талбай	ширхэг	65,000	10	650.0	2 дугаар улиралд	хамгаалах тухай хуулиуд
		3.3. Төлөвлөлтөөс гадуурх талбайд нүх ухах, зам талбай үүсгэх зэргээр хөрсний элэгдэл эвдрэлд орохоос сэргийлж, инженер техникийн ажилчдад анхааруулж байх	-Уурхайн бүх ажилчдад	хүн	шаардахгүй	200	шаардахгүй	Тухай бүр	
	-Хөрс хатуу, шингэн хаягдлаар бохирдох	3.4. Хог хаягдал ангилан хаях сав байршуулах, хог хаягдлыг бага дээр нь тогтмол түүж цэвэрлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	-ШТС, зөөврийн ШТС, түлш тээвэрлэгч машинууд -Засварын газар -Кемп	Ширхэг	50,000	10	500.0	Тухай бүр	Хөрсний чанрын стандарт MNS 5850:2008
4. Газрын хэвлий									
4	-Шатах, тослох материал (ШТМ) асгарч хөрсөнд нэвчих, ахуйн хог хаягдлаар хөрс бохирдох	4.1. ШТМ хадгалах технологийн горимыг чанд даган мөрдөж ажиллах,	-Петро Плас ХХК-ний ШТС, зөөврийн ШТС, түлш тээвэрлэгч машинууд -Засварын газар	Байнга	400,000	1 удаа	400	байнга	-Хөрсний чанрын стандарт MNS 5850:2008
		4.2. Сольсон, хуучин тослох материалыг хадгалах сав зэргийг байршуулж, тодорхой	-Засварын газар	тонн	500,000	10	Үйл ажилла-	1 удаа	-Байгаль орчныг

		хэмжээнд хүрмэгц тос боловсруулах аж ахуйн нэгжид хүргүүлж байх					гааны зардал		хамгаалах тухай хууль
5. Ургамлан нөмрөг									
5	-Хөрс хуулалтын явцад үүсэх тоос, хөрс хуулалтын машин техникээс ялгарах утаа, олон төрлийн хүнд элементүүд тухайн орчныхоо 15-50м зай доторх ургамлан нөмрөгийн фотосинтезийн идэвхтэй туяа шингээлтийг бууруулах	5.1. Уурхайн технологийн болон дотоод тээвэрлэлтийн зам, зогсоол, талбайд усалгаа хийж чийгшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	-Технилоги, тээвэрлэлтийн зам талбай	м³	Ус ашиглас-ны төлбөр	Ус ашиг-луулах дүгнэлт ээр	-	Бороо-гүй үед өдөр бүр.	Байгалийн ургамлын тухай
		5.2. Хүнд машин, механизм, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд мото цагийн техник үйлчилгээг графикт хугацаанд хийж, тос маслыг тогтсон хугацаанд нь сольж байна.	-Уурхайн хүнд болон бүх төрлийн машин, тоног төхөөрөмж	ширхэг	Үйлдвэр-лэлийн зардалд орно	100	Үйлд-вэр-лэлийн зардалд орно	Байнга	
	-Хүн, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, ургамалан нөмрөг сүйдэх, нөлөөлөлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй.	5.3. Үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад машин механизмуудын хөдөлгөөнийг хориглох, анхааруулсан тэмдэг байршуулж, хяналт тавих, ашиглалтгүй болсон хуучин замуудыг хаах.	-Төслийн талбай, ашиглалтгүй болсон замууд	ширхэг	25,000	20	500.0	4-11 дугаар сар	

6. Амьтны аймаг									
6.	-Уурхайн ойр орчимд тохиолдох зэрлэг амьтад үргэн дайжих, машинд дайруулах, амьдрах орчин хуваагдах, нүүдлийн зам хязгаарлагдах зэрэг нөлөөллүүд үүсэх	6.1. Зэрлэг амьтдыг үргээх зэрэг хууль бус үйлдэл гаргахгүй байх талаар нийт ажилчдад анхааруулж байх	- Нийт ажилчид -Төслийн талбай	Байнга	шаар-дахгүй	байнга	шаар-дахгүй	байнга	-Амьтны тухай хууль
	-Хөрс хуулалтын улмаас ухмал нүх үүсч, амьтад тухайн нүхэнд унаж үхэх	6.2. Уурхайн карьерын ирмэгээр хөмсөг далан хийж мал, амьтан унахаас сэргийлнэ.	-Уурхайн карьер, ус тунаах нуур	Бүх ухсан нүх, карьер	Хөрс хуулал-тын зардалд	Бүх ухсан нүх, карьер	Хөрс хуулал-тын зардалд	Тухай бүр	
	-Амьтдын амьдрах орчин доройтох, идэш тэжээлийн хомсдол буй болох	6.3. Биотехникийн арга хэмжээ авах/ Өвс, тэжээл, мөс тавих, зэрлэг ан амьтан ундаалах уст цэг бий болгох/	-Төслийн талбай, нөлөөллийн бүс	ш	2,000,000	1	2,000	4 дугаар улиралд	
	Нийт:	23 ажил, арга хэмжээ					6,500		

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гол онцлог бол “Мандах нуур” уурхайн ашиглаж дууссан карьерт дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийх бөгөөд хаалтын нөхөн сэргээлтийн эхний үе шатны хүрээнд хийгдэх байгаа ажил юм. Энэ нь ижил төрлийн уурхайнуудад төдийлөн хийгдэж байгаагүй томоохон хэмжээний карьерийг нөхөн сэргээх ажлын эхлэл юм.

Мөн ашиглахгүй болсон инженерийн зориулалттай суваг шуудуу булах, хөвөө далан, зам талбайг хэлбэржүүлэх, тэгшилж засах ажлууд хийгддэг. Мөн шимт хөрсний овоолгыг хэлбэржүүлэх, олон наст өвслөг ургамал тарьж салхи, усны нөлөөлөлд автах, элэгдэл эвдрэл орохоос урьдчилан сэргийлэх ажлууд хийгдэхээр төлөвлөлөө.

Төлөвлөгөөний хүрээнд ажилчдын байр орчмын ногоон байгууламжыг нэмэгдүүлэх мөн МУ-ын ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг хийж гүйцэтгэхээр тусгасан.

6.1. Шимт хөрсний нөхөн сэргээлт

2025 онд ил уурхайн хүрээний тэлэлтэд өртөх, шинээр үүсэх шимт хөрсний овоолгыг хэлбэржүүлж стандартын дагуу овоолго үүсгэн хадгална.

Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө (2025 он)

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Техникийн нөхөн сэргээлт	Ашиглах шаардлагагүй суваг шуудуу булж тэгшлэх	га	0.6	5250.0	5250.0	3-4 р улирал	Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээлт, техникийн ерөнхий шаардлага MNS5917:2008
		Дотоод овоолгоор карьерийн хоосон орон зайд дүүргэлт хийх	Мян.м3	Гүйцэт-гэлээр	Хөрс зардал	хуулалтын	4-р улирал	
2.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд	Кемп орчны тохижилтод мод тарих	ширхэг	500	7.5	3750.0	10-р сард	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн
	Нийт					9000.0		

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох нөлөөллийг шатлалтайгаар багасах зарчмыг баримтална. Энэ нь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа юун түрүүнд тэрхүү нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга замаар хийгдэнэ.

БОННУ-ний тайланд тусгаснаар дүйцүүлэн хамгааллын боломжит хувилбаруудыг тогтоосон байдаг. Үүнээс дараах 2 чиглэлээр орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөж дүйцүүлэн хамгааллын ажил хийхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Усны сан бүхий газрын бохирдол, хомсдлоос урьдчилан сэргийлэх. Аймаг, сумын засаг дарга, албаны бусад хүмүүс болон орон нутгийн иргэдтэй зөвлөлдөн уст цэг, булаг, шандын эх ундаргыг хашиж хамгаалах, худаг гаргах гэх мэт төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.
2. Зэрлэг ан амьтдад зориулсан биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх

Хүснэгт 8. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Усны сан бүхий газрыг бохирдол, доройтлоос хамгаалах	Сум орон нутагтай тохиролцож хийх	Мандах сум	1	2500.0	2500.0	8-9 сард	Усны тухай хууль
2.								
	Нийт					2500.0		

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Ашигт малтмалын тухай” хуулийн 41-р зүйлийн 41,1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна” гэж заасан.

Хуулийн дээрх зүйл заалтын дагуу олборлолтын бүсэд давхцалгүй боловч нөлөөллийн бүс дэх мал бүхий иргэдээс мах, сүү худалдан авах, өвс тэжээл хүргэх зэрэг малчдын өрхийн амьжиргааг дэмжсэн ажлыг энэ хэсэгт тусгасан болно.

Хүснэгт 8.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, сая.төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Мандах иргэд	Нөлөөллийн бүсийн айлуудад нөхөн олговор олгох	Алхан тээг багийн иргэд	Тухай бүр	гүйцэтгэлээр	гүйцэтгэлээр	Жилдээ	Ашигт малтмалын тухай хууль

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллана. Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, эдгээр газруудыг нэн даруй хамгаалж ажиллана.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн Байгаль орчны эрсдэлийн үнэлгээ, Хүний эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ, Осол аюулын эрсдэлийн үнэлгээ гэсэн 3 агуулгын хүрээнд БОННУ-нд эрсдэлийн үнэлгээг тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан.

Байгаль орчны эрсдэлийн хүрээнд хүрээлэн буй орчинд тархаж болох болон тархсан бохирдолтой (бохирдуулагч бодис) хүрэлцэх, түүний нөлөөлөлд өртснөөс экологийн бүрдэл хэсэгт үзүүлж болох эрсдэлийг тодорхойлсон байдаг.

Хүний эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээнд хүрээлэн буй орчинд тархаж болох болон тархсан бохирдолтой (бохирдуулагч бодис) хүрэлцэх болон түүний нөлөөлөлд өртснөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэл гарч болзошгүй.

Осол аюулын эрсдэлийн үнэлгээнд тоног төхөөрөмжийн эвдрэл, аваар осол, хүний алдаатай үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх системийн хэвийн бус ажиллагаанаас болон үер, газар хөдлөлт, гал түймэр, цаг агаарын хүчин зүйл гэх мэт байгалийн хүчин зүйлийн улмаас үүсэх системийн хэвийн бус ажиллагаанаас үүсэх эрсдэл.

Эдгээр аюул, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэл гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх ажлыг тусгасан “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г жил бүр батлуулан ажилладаг.

Уурхайн “ХАБЭАБО”-ны хэлтсийн бүрэлдэхүүнд 3 хүнтэй орон тооны Галын аюултай тэмцэх хэсэг ажилладаг бөгөөд галын зориулалтын машин, багаж тоног хэрэгслээр хангагдсан байдаг. Мөн уурхайн даргын тушаалаар Гамшигийн үед ажиллах шуурхай хэсгийг томилон, ажиллах зааврыг батласан байдаг.

Доорх хүснэгтэд болзошгүй аюулаас сэргийлэх арга хэмжээг тусгав.

Хүснэгт 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Болзошгүй осол, саатал, химийн бодис асгарах, техник технологийн дуу чимээ, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Нийт техник хангамж, барилга байгууламжид	Шаардах-гүй	Шаардах-гүй	Улирал бүр	“Гамшгаас хамгаалах тухай” хууль
	Шатах тослох материал, шатахуун асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслийг ажлын талбарт бэлэн байлгах	Төслийн талбайд, ШТС орчимд	Үйл ажиллагаа ны зардалд тусгагдсан	-	Тогтмол	
	Ажилчдад хор тайлах бүтээгдэхүүн олгож байх /витаминжуулсан ундаа, сүү/	Бүх ажилчдад	1000.0	1000.0	байнга	
Гал унтраах багаж хэрэгсэл, галын аюулаас сэргийлэх	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчдад	Шаардах-гүй	Шаардах-гүй		
	Гал түймрээс урьдчилан сэргийлэх тусгай бүдүүвч схем боловсруулан батлах, гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах	Төслийн хүрээнд	ХАБ-н зардал	ХАБ-н зардал		
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох дүүргийн байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Бүх ажилчдад	400.0	400.0		

	Ажилчдыг ХХАА-ны багаж, хувцас хэрэгслээр хангаж ажиллах	Бүх ажилчдад	ХАБ-н зардал	ХАБ-н зардал	Улирал бүрийн хувцас	
	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг хамруулах	Бүх ажилчдад	ХАБ-н зардал	ХАБ-н зардал	Жилд 2 удаа	
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал			1,400,000 төгрөг			

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зорилго нь хог хаягдлаас үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа явуулахад оршино.

Хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлж, хэвшүүлэх эхний алхам нь ангилан ялгалт, дахин ашиглалт юм. Иймд ангилан ялгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хог хаягдлын үүсвэрүүдийг тодорхойлж, тохирох хогийн савыг байрлуулж бүх ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар зааварчилгаа өгч ажиллана.

Уурхайн үйл ажиллагааны явцад гарч байгаа хог хаягдлыг дараах байдлаар шийдвэрлэнэ.

Хаягдал мод: Үйл ажиллагааны явцад гарч байгаа модны хаягдлыг кемпийн тохижилт, халаалтанд ашиглах

Кемпээс үүсч байгаа үнсийг түр хадгалах цэгт цуглуулж булшлах

Хаягдал тос болон тосолгооны материал: Тосыг төрлөөр ялган цуглуулж шүүн ашиглах мөн тос цуглуулах нөөцийн саванд цуглуулж тодорхой хэмжээнд хүрсний дараа дахин боловсруулахаар Улаанбаатар хот дахь гэрээт компанид хүргэх

Дугуй: Дахин ашиглах боломжгүй хогийн цэгт цуглуулах, тэмдэг тэмдэглэгээний суурь хийх

Хуванцар сав: Хуванцар савыг тусгай цэгт цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлэх

Хаягдал төмөр: Төслийн талбайд гарч байгаа нийт хаягдал төмрийг тусгай талбайд цуглуулж байгаа бөгөөд дахин ашиглах

Асгаралтын явцад бохирдсон хөрс: Бохирдсон хөрсийг хаягдлын овоолго дээр тусгайлан бэлтгэсэн талбай дээр асгах, саармагжуулах

Цаас ба картон: Оффисоос гарч буй цаас болон бусад картон цаасыг цуглуулж, шатаах зууханд шатаах

Эмнэлгийн хог хаягдал: Сумын эмнэлэгтэй гэрээ байгуулж, зориулалтын аргаар устгуулах

Тостой арчих материал ба тосны шүүлтүүр: Тостой арчих материалыг шатаах зууханд шатааж байна. Тосны шүлтүүрийг тусгай зөвшөөрөл бүхий компанид нийлүүлэх, агаар шүүгчийг хогийн сав хийн дахин ашиглах

Хоолны хаягдал: Хоолны үлдэгдлийг ариутгал хийж ландфиллын аргаар булшлах, гахайн идэш тэжээл болгон нийлүүлэх

Ахуйн бусад хог хаягдал: Ахуйн бусад хог хаягдлыг хогийн саванд хийж, түр хадгалах цэгт цуглуулах сумын хогийн цэгт хаях

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	11.1.1. Хог хаягдлын гэрээг орон нутагтай байгуулж, төлбөрийг гэрээний дагуу төлөх	Мандах сум	ш	150,000	12	1,800,000	1-4 р улирал	Хог хаягдлын тухай хууль
		11.1.2. Ахуйн хог хаягдлыг төрөлжүүлэн ангилан ялгах, хог хаягдлын төрлийг ялгасан хогийн сав байрлуулах	Кемп	ш	50,000	5	250,000	10-р сард	
		11.1.3. Ажилчдыг хот хооронд зорчихдоо хог хаягдал ил зайдгай хаяхгүй байх баталгаа гаргуулах, тээврийн хэрэгслийг хог хаях савтай байлгах	Уурхайгаас УБ хот болон бусад аймаг, сум	ш	Зардал шаардах -гүй	байнга	-	байнга	
		11.1.4. Дулааны улиралд хогийн сав, гал тогоо, ариун цэврийн байр, хогийн цэгт ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Хогийн цэг, шингэн бохирын худаг, бие засах газар	кг	50,000	18	900,000	10 хоног тутам	
		11.1.5. Орчны хог хаягдалд тогтмол хяналт тавьж, 1 сар тутам орчны цэвэрлэгээг хийнэ.	Кемп орчим	ш	Зардал шаардах -гүй	24	-	7 хоног тутам	
		11.1.6 Хог хаягдлын цэгийг хашаажуулан, хаяг тэмдэг хийх	Хогийн цэг	ш	650,000	1	650,000	4-9р сард	
		11.1.7. Ахуйн шингэн бохирыг цэвэршүүлсэн усыг шинжилгээнд хамруулах	Шингэн бохирын худаг	ш	240,000	2	ОХШХ-н зардал	6, 9 дүгээр сард	

2.	Үйлд- вэрийн	11.2.1. Засварын газраас гарах ашигласан тос, нефть бүтээгдэхүүнийг цуглуулан, хадгалах, дахин ашиглан гэрээт компанид гэрээний дагуу нийлүүлэх	ШТС Засварын газар	тонн	500,000	6	ҮА-ны зардал	9 дүгээр сард	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
		11.2.2. Хаягдал дугуй, төмөрийн хогийг түүхий эдэд тушаана.	Засварын газар	Ш, тонн	Зардал шаардах -гүй	1	-	9 дүгээр сард	
3.	Аюултай	Эмнэлгийн хог хаягдлыг Хатанбулаг сумын эмнэлэгт хүргэж зориулалтын дагуу устгуулна.	Уурхайн эмнэлэг	кг	50,000	6	400,000	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль
	Нийт						4,000,000		

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа байгаль орчны хууль, тогтоомжийг баримталж, төлөвлөгөө, гэрээнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалт, дотоод хяналтын арга хэмжээг авч, орон нутагт тайлагнах, сурталчлах, байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжиж ажиллана. Доорх ажлуудыг компанийн захирал тушаал гаргаж баталгаажуулна.

Хүснэгт 12.Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Cap ...	Cap ...	Cap ...		
	1	2	3	4	5	6	7
1	Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг, хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Шаардахгүй	3	-	10	-Байгаль орчны ажилтан -Дотоод хяналтын ажилтан	Уурхайд байгаль орчны талаар мөрдөх дүрэм, журам
2	Уурхайн үйл ажиллагаа явуулахад шаардагдах төлөвлөгөө, гэрээ холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн ажиллана.	Шаардахгүй	1	-	6	-Байгаль орчны ажилтан -Үйл ажиллагаа-ны менежер	БОМТ, АҮАТ, ус, газрын, хог хаягдлын гэрээнүүд гэх мэт
3	Мандах сумын БОХУБ, байгаль хамгаалагч нартай усны тоолуурын баталгаажуулалтыг хийж байх	1,200	1	-	12	-Байгаль орчны ажилтан	Худгийн тоолуурын заалтыг баталгаажуулах
5	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	ХАБ-н зардал	2	7	11	-ХАБЭАБО хэлтэс - Галын ажилтан -Байгаль орчны ажилтан	-

	талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.						
6	Ижил төстэй уурхайн сайн жишээ, нөхөн сэргээлтийг үзэж, туршлага солилцох	Шаардахгүй	6	-	-	-Байгаль орчны ажилтан	
7	Багийн ИНХ-д оролцож тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	1,600	12	-	-	-Байгаль орчны ажилтан -Үйл ажиллагааны менежер	-Багийн хуралд оролцож мэдээлэл өгөх, санал шүүмжлэл хүлээн авах
	Нийт	2,800.0					

13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг гадаргын болон газрын доорх ус, агаар, хөрсний шинжилгээний хүрээнд итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлэхээр төлөвлөж байна.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго:

- о БОННУ-ний судалгаагаар урьдчилан гаргасан нөлөөллүүдийг хүлээн зөвшөөрсөн хэмжээнд байлгах
- о Уурхайн нөлөөлөлд өртөж болзошгүй болон хяналтын байршилд мониторинг хийх цэгүүдийг сонгож байгалийн өөрийн өөрчлөлт ба уурхайн нөлөөллөөс үүсэх өөрчлөлтийг харьцуулан судлах бололцоо олдохуйц мэдээлэл бүрдүүлэх
- о Мониторингийн ажлын үр дүнг байгаль орчны менежментийн үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх

Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.Агаарын бохирдлын үзүүлэлт								
1.	Нүүрстөрөг-чийн исэл, Хүхэрлэг хий, Азотын исэл	1.Ажилчдын хотхон 2.Технологийн зам	6, 9 дүгээр сард	2 удаа	30,000	180,000	3 цэгээс	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007
2.	Тоосжилт , дуу чимээ	3.Уурхайн карьер			25,000	150,000	3 цэгээс	
2. Усан орчин								
1.	Усны ерөнхий үзүүлэлт. Ерөнхий хатуулаг, рН, цахилгаан дамжуулах чадвар, өнгө, атуулаг, хлорид, аммони,	1. Унд ахуйн худаг 2. Шүүрлийн ус	6, 9 дүгээр сард	2 удаа	250,000	500,000	Худаг болон шүүрлийн усны эх үүсвэр 4 цэгээс	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага.MNS 4586:1998

	нитрит, нитрат, фтор, фосфат,							
2.	Унд ахуйн усны микробиологийн шинжилгээ	1. Унд ахуйн худаг	6, дүгээр сард	9 2 удаа	60,000	120,000	1 цэгээс	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018/ стандарт
3.	Цэвэршүүлсэн бохир ус	1. Цэвэрлэх байгууламж	Улирал тутам	4 удаа	960,000	3,840.00	1 цэг	
3. Хөрсний шинжилгээ								
1.	Хөрсний химийн үндсэн шинж, механик бүрэлдэхүүн	1.Кемп 2. Шимт хөрсний овоолго	6, дүгээр сард	9 2 удаа	57,000	114,000	2 цэгээс	Хөрсний стандарт. MNS 3985-87,
2.	Хөрсний бохирдлын үзүүлэлтүүд Хүнд металлууд (Cr, Pb, Ni, Zn)	1.Засварын газар 2.Карьер 3. ШТС	6, дүгээр сард	9 2 удаа	2,000,000	4,000,000	3 цэгээс	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850 : 2008
	Бүгд:					8,904,000		
1.	Шинжилгээний дээж авах ажлын зардал			2 удаа	1,248,000	2,496,000		
Нийт						11,400,000		

14. БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ

Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан /ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	-БОУАӨЯам, -Дорноговь аймгийн Байгаль орчны газар, -Мандах сумдын БОХУБ	Хэвлэмэл тайлан	-2025 оны БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, мэдээнүүд.	Аймгуудад 11-р сарын 01 дотор, Дүгнэлт гарсаны дараа БОУАӨЯ-д	Шаардахгүй	-Уурхайн дарга -Байгаль орчны ажилтан	-
2.	-БОУАӨЯам, -Дорноговь аймгийн Байгаль орчны газар, -Мандах сумдын БОХУБ	Батлагдсан хэвлэмэл тайлан.	-2025 оны БОМТөлөвлөгөө хянуулж батлуулан, холбогдох газруудад хүргүүлэх. -Шинээр батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдэх нөхөн сэргээлт, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хуулийн хугацаанд	Шаардахгүй	-Байгаль орчны ажилтан -Төлөвлөлтийн инженер	-
3.	-Дорноговь аймгийн Мандах сумын ИТХурал, Алхан тээг багийн ИНХ,	Илтгэл, брошур	-Нөхөн сэргээлтийн ажлын жилийн тайлан, Ус, газрын гэрээ, төлбөрийн мэдээлэл, -Нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилт. -Тухайн жилийн батлагдсан БОМТ-ний зорилго, хэмжээ, хэрэгжүүлэх чиглэл	10 дугаар сард	Оффисын зардал	-Уурхайн дарга -Байгаль орчны ажилтан -Үйл ажиллагааны менежер	-Багийн байр

4.	ОҮИТБС-ын ажлын алба, олон нийт	Цахим тайлангийн систем	-Нөхөн сэргээлт -Татвар, төлбөр, хандив	Хуулийн хугацаанд	Шаардахгүй	-Ерөнхий нягтлан бодогч	-
5.	Уурхайн ойр орчимд байдаг малчид, иргэд	Уулзалт, танилцуулга	-Олон нийтэд нээлттэй байх -Багийн иргэдээс сонгогдсон төлөөллийг уурхайд хүлээн авч, бичиг баримтаа танилцуулж, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, явцтай танилцуулах.	Тухай бүр	Шаардахгүй	-Уурхайн дарга -Үйл ажиллагааны менежер -Байгаль орчны ажилтан	-Уурхай дээр
	Нийт						

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

№	Материал	Хуудас
1	Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ	1
2	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтын хуулбар. /MV- 017196 /	3
3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудас	8
4	2025 оны Уулын ажлын төлөвлөгөөний баталгаажсан нүүр	1
5	2025 оны Уулын ажлын төлөвлөгөөний Байгаль орчинтой холбоотой маягтууд	5
6	Байгаль орчныг хамгаалах баталгааны мөнгөн хөрөнгө байршуулсан баримт	1
7	Нөхөн сэргээлт, ОХШХ-ийн цэг, бусад мэдээлэл агуулсан зураг	1
	Нийт:	25